



73

**ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2022 оны 03 сарын 03 өдөр

Дугаар А/29

Эрдэнэт

Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдад хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 18.4 дэх заалт, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2009 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 53/45 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад олон улс, тив, дэлхийн спортын тэмцээн, наадмыг зохион байгуулах, санхүүжүүлэх журам"-ын 4.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Гүйлтийн цанын насанд хүрэгчдийн улсын аварга шалгаруулах тэмцээн нь Өвөрхангай аймгийн Бат-Өлзийт суманд 2022 оны 03 дугаар сарын 06-09-ны өдрүүдэд зохиогдох тул багийн 6 тамирчин, 1 дасгалжуулагч, 1 жолоочийн байр, хоол, унааны зардлын төсөвт 1,071,730 (нэг сая далан нэгэн мянга долоон зуун гуч) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2. Тэмцээнд 1,071,730 (нэг сая далан нэгэн мянга долоон зуун гуч) төгрөгийг зохих журмын дагуу спорт арга хэмжээний зардалаас гаргаж, аймгийн Ирээдүйн Хос мөртөн цанын холбооны дансанд шилжүүлэхийг нягтлан бодогч (Б.Мөнхцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА  Д. ДЭЛГЭРБАЯР



74
Биеийн тамир, Спортын газрын даргын
2022 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн
Аг дугаар тушаалын хавсралт



ГҮЙЛТИЙН ЦАНЫН НАСАНД ХҮРЭГЧДИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ
ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

Замын зардал-Шатахуун - Эрдэнэт- Өвөрхангай /100км-20л-А92/

1 талдаа 420км х 2талдаа=840км,

дотор үйлчилгээнд-160км

168л х 2,390төгрөг= 401,250 төгрөг,+ 32л х 2390= 76,480 төгрөг

1.Шатахуун А92-200л х2,390 төгрөг = 477,730 төгрөг

Тосол, масло х 18,000 = 18,000 төгрөг

2.Тамирчид Байр хоол 6 хүн х 3 хоног х 8,000 төгрөг= 144,000 төгрөг

Хоол 6 хүн х 5 хоног х 8,000 төгрөг= 240,000 төгрөг

3.Дасгалжуулагч, жолооч

Байр 2 хүн х 3 хоног х 12,000 төгрөг= 72,000 төгрөг

Хоол 2 хүн х 5 хоног х12,000 төгрөг= 120,000төгрөг

Төсвийн нийт дүн: 1,071,730 төгрөг

----oOo----